



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

“Фрэйндс файнэнс” ХХК-д банк бус санхүүгийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 3.2 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Фрэйндс файнэнс” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Фрэйндс файнэнс ББСБ” ХХК /С.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГЭГЧ
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

